“АЛТАЙН ЗАМ” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС

ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны **10** сарын **06** өдөр Дугаар **АЗХЭ2026005** Улаанбаатар хот

Компанийн хэлбэр өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 24.1, 53.1.1, 62.1.4, 62.1.12, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасний бүртгэлийн журам”-ын 6.1.1, 6.3, “Алтайн зам” ХК-ийн дүрмийн 5.2.1, 5.2.5.1, 7.7.1, 7.7.2 дугаар заалтууд, Хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураасан дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Алтайн зам” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оруулсан компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл болон төслийг хэрэгжүүлэх журмыг энэхүү тогтоолын **Хавсралт 1**-ээр баталсугай.
2. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчилснийг баталсугай.
3. Компанийн хэлбэрээ өөрчилсөн нь “Алтайн зам” ХК-ийн эрх, үүрэг, хариуцлага шинээр бий болсон “Алтайн зам” ХХК-д шилжиж байгаа болон хуулийн этгээдийн оноосон нэрэнд өөрчлөлт ороогүй болохыг тус тус дурьдсугай.
4. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэр өөрчилсөнтэй холбогдуулан компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон ТУЗ-ийн бүрэн эрхийг Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны бүртгэлээс хасах тогтоол гаргах болон компанийн хэлбэр өөрчлөгдөж Улсын бүртгэлд бүртгүүлэх хугацаанд үргэлжилүүлсүгэй.
5. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар Компанийн хэлбэр өөрчилсөнтэй холбоотойгоор холбогдох хууль журамд заасан Брокерын болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулах зэрэг өөрчлөн зохион байгуулагдахад шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах, төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /С.Баянцогт/-д олгосугай.
6. Компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь компанийн хэлбэрийг өөрчилөхөд эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй болохыг дурьдаж хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг ТУЗ-д зөвшөөрсүгэй.
7. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд болон холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, бусад шаардлагатай ажиллагааг энэхүү шийдвэрийг үндэслэн итгэмжлэлгүйгээр хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /С.Баянцогт/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА М.НЯМДАВАА